

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны ... дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар ..... / .....

Улаанбаатар  
хот

Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тооцоход Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ, холбогдох нэмэгдлийг тус тус баримталсугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны сайд, Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/48, А/130 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Б.БАТЦЭЦЭГ

Х.БУЛГАНТУЯА

Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр,  
нийгмийн хамгааллын сайдын 2023  
оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... / ..... дугаар хамтарсан тушаалын  
хавсралт

Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын  
ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх,  
тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээ

№	Дипломат төлөөлөгчийн газрын албан тушаал	Гадаад харилцааны яамны адилтгах албан тушаал	Жишиг цалин хөлсний хэмжээ
1.	Элчин сайд	Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-1
	Байнгын төлөөлөгч		
	Ерөнхий консул		
2.	Элчин	Газрын захирал	ТЗ-2
	Хэргийг хамаарагч		
	Байнгын төлөөлөгчийн орлогч		
	Элчин зөвлөх		
3.	Цэргийн атташе	Газрын дэд захирал	ТЗ-3
	Консул (Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн)		
	Консулын хэлтсийн дарга		
4.	Зөвлөх	Зөвлөх	ТЗ-4
5.	Нэгдүгээр нарийн бичгийн дарга	Нэгдүгээр нарийн бичгийн дарга	ТЗ-5
	Консул		
	Худалдааны төлөөлөгч		
6.	Хоёрдугаар нарийн бичгийн дарга	Хоёрдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-6
	Дэд консул		
	Консулын төлөөлөгч		
	Цэргийн атташегийн туслах		
7.	Гуравдугаар нарийн бичгийн дарга	Гуравдугаар нарийн бичгийн дарга	ТЗ-7
8.	Атташе	Атташе	ТЗ-8
9.	Ахлах нягтлан бодогч	Ахлах мэргэжилтэн	ТЗ-6
		Ахлах нягтлан бодогч	ТҮ-9
10.	Консулын техник ажилтан	Мэргэжилтэн	ТЗ-9
11.	Аж ахуйн эрхлэгч-жолооч	-	ТҮ-7

	Ажил эрхэлж буй төвийн томилолттой ажилтны гэр бүл	-	
12.	Жолооч, сантехникч, мужаан	-	ТҮ-6
13.	Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний томилсон үйлчилгээ техникийн ажилтан	-	ТҮ-5
14.	Төвийн томилолттой ажилтны ажил эрхлээгүй гэр бүл	-	НДЕХ-ийн 7.4.6, 21.15-д зааснаар
15.	Төвийн томилолттой ажилтны дипломат албан тушаалтай гэр бүл	Тухайн ажилтны сүүлд эрхэлж байсан албан тушаалын ангиллаар	

---oOo---